

Анагаахын дискурс, бүтцийн өөрчлөлт: Анагаахын хүртэхүйн хувьслын талаарх М.Фукогийн үзэл

Д.Авирмэд, докторант

АШУУИС, Эрүүл мэндийн нийгмийн ажил, нийгмийн ухааны тэнхим

Ц.Нямсүрэн, доктор (Ph.D), дэд профессор

МУИС, Философи шашин судлалын тэнхим

Хураангуй: Мишель Поль Фуко (1926-1984) соёлын онол судлаач, түүхч, түүхийн философийн төлөөлөгч юм. Уг өгүүлэлд М.Фукогийн 1963 онд хэвлүүлсэн “Клиникийн үүсэл” бүтээл дэх анагаахын дискурс, бүтцийн өөрчлөлтийн талаар өгүүлэх болно. М.Фуко уг бүтээлдээ XVIII зуунаас XIX зууны эхэн хүртэлх Францын анагаах ухааны түүхийг цэвэр дискурсээр дамжуулан задлан шинжилжээ. Түүнийхээр анагаах ухааны мэдлэг хэрхэн хурдацтай хөгжиж буйг хоорондоо 100 хүрэхгүй жилийн ялгаатай бичигдсэн эмч нарын эмчилгээний тайлангаар тайлбарладаг. Мөн тэрээр хүн төрөлхтний эхэн үеийн анагаахын мэдлэг онолын хувьд багшаас шавьд гэсэн босоо тэнхлэгтэй байсан нь XIX зууны эхэн үеэс өөрчлөгдөхөд туршилагын мэдлэг, түүний бүтцийн өөрчлөлт нөлөөлсөн хэмээн үзжээ. М.Фуко анагаах ухааны мэдлэгийг системтэй олгох зорилгоор үүссэн прото клиникүүдийн талаарх дискурсуудыг задлан шинжилж, клиник болон прото клиникт өвчтөн, өвчин хоёрын байр суурь ямар ялгаатайг өвөрмөцөөр тайлбарладаг.

Түлхүүр үг: Структурализм, дискурс, дискурсын ялгаа, өвчин, өвчтөн, прото клиник, клиник

Мишель Поль Фуко (1926-1984) соёлын онол судлаач, түүхч, түүхийн философийн төлөөлөгч юм. Түүний үзэл баримтлал структурализм, постструктурализмтай холбоотой төдийгүй түүний бүтээлийн талаар судалгаа хийдэг олон судлаач түүнийг структуралист, постструктуралист, постмодернист төлөөлөгчдийн нэг хэмээн эшлэх нь бий. Мөн М.Фуког “структуралист” гэж тодорхойлохыг эсэргүүцдэг хүмүүс ч байдаг. Судлаачдын ийнхүү ялгаатай өнцгөөс түүний үзэл баримтлалыг тодорхойлж буй нь М.Фукогийн эхэн үеийн болон хожуу үеийн бүтээлүүд дэх үзэл баримтлал структурализмаас постструктурализм руу, улмаар постмодернизм руу шилжсэнтэй холбоотой.

Структурализм¹ нь соёлын янз бүрийн салбар дахь бүтцийг илрүүлэн тайлбарладаг нийгмийн шинжлэх ухааны болон хүмүүнлэгийн ухааны төрөл бүрийн салбаруудын арга (Отгонбаяр, М ба бусад., 2023, х.174) бөгөөд 20-р зууны эхэн үед, Фердинанд де Соссюр (1857-1913) болон түүний залгамжлагчдын нөлөөгөөр ялангуяа Франц, Оросын эзэнт гүрэнд хурдацтай хөгжсөн байна. Учир нь Прага, Москва, Копенгагений их сургуулиудад хэлний дугуйлангууд бий болж, хэл шинжлэлд структурализмыг нэвтрүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн (Гомбосүрэн, Ц. 2010).

Дэлхийн II дайны дараа хүмүүнлэгийн чиглэлээр ажилладаг олон эрдэмтэд Ф.де Соссюрын үзэл баримтлалыг өөрсдийн салбарт нэвтрүүлж эхэлсэн. Тэдний хамгийн гарамгай төлөөлөгч бол Францын антропологич Клод Леви-Строс (1908-2002) юм. Тэрээр хэл шинжлэлийн салбарт бий болсон бүтцийн онолын баримтуудыг бичиг үсэггүй эртний нийгмүүдийн соёлын материалыг судлахдаа ашиглах үндсэн дээр анх структурализмыг философи онол болгосон (Отгонбаяр, М ба бусад., 2023, х.176) байна. К.Леви-Строс хүний харилцаа холбооны гол нэгж хэл боловч зөвхөн хэлээр биш соёлоор тэр дундаа ураг төрөл,

¹ Доктор (Sc.D), профессор Ц.Гомбосүрэн “Философийн структурализм бол структурализмын зөвхөн нэг бүрэлдэхүүн бөгөөд онолын цөм нь байдаг” хэмээн тайлбарлажээ. Мөн тэрээр “философийн структурализм”, “структурализм” гэдэг хоёр нэр томъёог ижил утгаар хэрэглэдэг нийтлэг жишгийг дагаж буй тухайгаа өөрийн ном, өгүүлэлдээ олон дурддаг. Иймд энэ өгүүлэлд мөн адил тус хоёр нэр томъёог ижил утгаар хэрэглэв.

шашин, солилцооны хэлбэрүүд ч гэсэн хэлний адил харилцаа холбоог тогтоож утга дамжуулдаг (Бум-Очир, Д., Мөнх-Эрдэнэ, Г., 2018, х.143) гэж үзсэн. Структурализм хүчээ авч байх үед К.Леви-Строс, Роланд Барт (1915-1980), Жак Лакан (1901-1981), М.Фуко нар структурализмын “дөрвийн бүлэг” /Gang Four/ (Hurst, 2017) хэмээн нэрлэгдэж байсан ч аажимдаа К.Леви-Стросоос бусад нь структурализмаас татгалзан постструктурализмд, сүүлдээ постмодернизмд шилжсэн байдаг.

М.Фукогийн бүтээлүүдийн талаар судалгаа хийдэг олон судлаачид түүний үзэл баримтлалыг янз бүрээр ангилж байгааг доктор (Sc.D), профессор Ц.Гомбосүрэн 2006 онд хэвлүүлсэн “Структурализм ба эдүгээ үеийн түрүү философидолт” бүтээлдээ дурдаад, тэдгээрийг нэгтгэн дараах үечлэлийг бий болгожээ. Үүнд:

1. Структурализмд шилжээгүй байсан үеийн,
2. Структуралист үеийн,
3. Постструктуралист үеийн,
4. Постмодернист асуудал дэвшүүлсэн үеийн хэмээх дөрвөн үе багтжээ.

Уг өгүүлэлд онцлох М.Фукогийн 1963 онд хэвлүүлсэн “Клиникийн үүсэл” бүтээлийг судлаач дээрх үечлэлийнхээ 1-р үеэс 2-р үе рүү шилжих үеийн бүтээлд (Гомбосүрэн, Ц., 2006, х.53) хамруулжээ.

Судлаач Хуберт Дрейфус (1929-2017) “Клиникийн үүсэл” бүтээлийн зорилгын талаар дүгнэн өгүүлэхдээ “1960-аад онд Францад бий болсон структуралист давалгаанд хүчтэй өртөж, даган орсон Фукогийн хувьд ... онол, дискурс, практикийн цаана агуулагдах бүтцийг илрүүлэн ойлгосноор хүний тухай ‘шинжлэх ухаанч’ ойлголтыг боловсруулах явдал” байсан (Dreyfus, H. 1983, p.12) хэмээн үнэлсэн билээ.

Дээрх хоёр мэдээнээс бид тус бүтээл нь структуралист үеийн М.Фукогийн бүтээл, эсвэл структурализмд шилжиж эхэлсэн үеийн М.Фукогийн бүтээл хэмээн дамжин мэдээлэх бүрэн боломжтой юм.

М.Фуко энэхүү бүтээлдээ XVIII-XIX зууны эхэн үеийн Францын клиникийн үүслийг шинжилсэн байдаг. Ингэхдээ институтжсэн анагаах ухаан бүрэлдсэн үеийн түүхийг зөвхөн дискурс хэрэглэх шинэ аргаар судалж буйгаа онцолдог. Хэдийгээр түүний энэхүү арга нь тухайн үед Францад хүчтэй давллагаа үүсгэж байсан структуралист үзэлтэй төстэй байсан ч тэрээр уг нэршлийг дагаагүй юм. Гэвч түүний “Клиникийн үүсэл” бүтээлд хүн төрөлхтний практикийг герменевтик тайлбарлал ашиглан нэг төрлийн структурализм руу шилжүүлсэн агуулга цөөнгүй байдаг.

“Клиникийн үүсэл” бүтээлийн өмнөх үг нь Поом² хэмээх эмч хийрхэх өвчтэй бүсгүйг “бүтэн арван сарын турш өдөрт 10-12 цаг усанд байлган” эмчилж, “чийгтэй хальсархаг маягийн мембраны эдүүд ... бага зэрэг өвдөлттэй хууларч, шээсээр өдөр бүр гадагшилж байлаа; шээсний баруун суваг нь мөн хууларч, бүхлээрээ гарч ирсэн” (Foucault, M. 1973, p. ix) тухай тайлангаар эхэлдэг. Мөн тус тайлангийн араас “архаг менингитээр өвчилсөн өвчтөнүүдэд ихэвчлэн тохиолддог хуурамч мембранууд гэж нэрлэгддэг тархи болон түүний бүрхүүлийн анатомийн гэмтэлийг тодорхойлсон Бэйл эмчийн” (Foucault, M. 1973, p. ix) “Хатуу бүрхүүлийн хөөсөн давхрагын зэргэлдээх тэдний гаднах гадаргуу нь энэ давхаргатай заримдаа маш сул наалдсан байдаг, ийм үед амархан сална, заримдаа маш бат, нягт наалдсан байдаг, энэ тохиолдолд тэднийг салгах маш хэцүү. Тэдний дотоод гадаргуу нь хөөсөн давхрагатай зүгээр л шүргэлцсэн, түүнтэй холбогдоогүй байна. Хуурамч мембранууд нь ялангуяа маш нимгэн үедээ ихэвчлэн тунгалаг

² Поом хэмээх эмчийн нэгэн эмчилгээний тухай М.Фуко уг бүтээлээ эшлэсэн байсныг энд дам эшлэв. Тус эмчилгээний талаар дараах эх материалаас үзнэ үү.
Pomme, Traité des affections vaporeuses des deux sexes (4th edn., Lyons, 1769, vol. I, p. 60–5) -ээс үзэж болно.

байх боловч голдуу цагаан, саарал эсвэл улаан, хааяа шар, хүрэн эсвэл хар өнгөтэй. Энэ нь ихэнхдээ нэг мембраны өөр өөр хэсгүүдийн ялгаатай сүүдрийг илтгэдэг. Дайвар эдгээр бүтээгдэхүүний зузаан нь маш их ялгаатай, заримдаа аалзны тортой харьцуулж болмоор хариугүй... Мөн хуурамч мембрануудын зохион байгуулалт нь үй олон ялгааг харуулдаг: нимгэн нь өндөгний уурган хальс шиг цайвардуу, өөрийн гэсэн өвөрмөц бүтэцгүй. Нөгөөдүүл нь өөр өөр чиглэлд нэг нэгэнтэйгээ огтолцсон, нийлсэн судсан мөртэй. Тэд бие бие дээрээ давхарлан байрлаж болох бөгөөд дундуур нь өнгөгүй цусан бүлэгнэл байнга тааралдана” хэмээн өгүүлсэн тайлан үргэлжилдэг. Эдгээр тайлангийн хооронд зуу хүрэхгүй жил байгааг М.Фуко онцолдог. Ингэж онцлох болсон нь эдгээр тайлангийн бичиглэлд хамааралтай. Энэ талаар тэрээр “Бэйлийн үгнүүд³ бидний харцыг байнгын харагдахуйц ертөнц рүү чанарын нарийвчлалтай чиглүүлдэг бол Поом ямар нэг ойлголтын үндэсгүй, уран зөгнөлийн хэлээр бидэнтэй ярьдаг” (Foucault, M. 1973, p. x) хэмээн тодорхойлжээ.

Поом, Бэйл хоёрын эмчилгээний тайлангаар бүтээлээ эхлүүлсэн М.Фукогийн шийдлийг Х.Дрейфус “нэгэн цагт объектив тайлбар хэмээн нухацтай авч үзэж байсан тодорхойлолт ямар утгатайг ч мэдэхгүй байгааг маань ойлгуулан цочирдуулах М.Фукогийн стратеги” (Dreyfus, H. 1983, p.13) хэмээн тайлбарладаг. Харин М.Фуко ийнхүү бичих болсон нь “клиникийн үүслийн тухай дискурсыг үндэслэх арга зам” (Foucault, M, 1973, p. xv) хэмээн үзэж байв. Учир нь түүнийхээр Поом, Бэйл нарын тайлан бол бүтцэд нь өөрчлөлт орсон мэдлэгийн ялгаа бөгөөд “үг ба юмсын хооронд шинэ холбоо бий болж, улмаар хүний харах болон хэлэх боломж илүү нэмэгдсэн” (Foucault, M, 1973, p. xii) байдлын илрэл ажээ.

XVIII зууны үеийн клиникийн дүр төрх хэрхэн өөрчлөгдөж, шинэ бүтэцтэй болж буйг эмч, өвчтөн хоёрын харилцан яриа эхлэх үеэс л мэдэж болно хэмээн М.Фуко баталдаг. Түүнийхээр “танд юу тохиолдов?” хэмээх урьдын асуулт XIX эхээр “таны хаана өвдөж байна?” гэсэн асуултаар солигдсон нь анагаах ухааны туршлагын бүх түвшинд тэмдэглэгч, тэмдэглэгдэгчийн бүхэл бүтэн харилцаа дахин хуваарилагдсаны нотолгоо байв. (Foucault, M, 1973, p. xviii)

Мөн тэрээр хүн төрөлхтний эхэн үеийн анагаахын мэдлэгийг туршлага гэхээсээ зөн совин, итгэл үнэмшилд суурилсан мэдрэмжийн харилцаанд тулгуурлаж байсан хэмээн үнэлжээ. Ингэж үнэлэх шалтгаан нь эхэн үеийн анагаах ухааны мэдлэг бясалгасан шинжтэй, багшийн заасныг шавь ямар ч шүүлтүүргүй сохроор хүлээн авч, шууд дагадаг байдалтай холбоотой. Тэрээр энэхүү үнэлэлтээ “дээхэн үед анагаах ухааныг объектын дэргэд зааж, залуус өвчтөний орны дэргэд анагаах ухаанд суралцаж, өвчтөнүүдийг ихэвчлэн эмчийн гэрт байрлуулж, суралцагчид нь бүх цаг үед өвчтөнүүдээ тойрон үздэг багш нараа дагалддаг⁴” (Foucault, M, 1973, p.56) гэсэн эшлэлд үндэслэдэг.

XVIII зууны сүүлийн жил хүртэл анагаах ухааны түүхэнд олон сургалтын клиникүүд⁵ бий болсон нь энэ салбарын бас нэг зохион байгуулалтын өөрчлөлт гэж М.Фуко үзсэн.

³ Бэйлийн тайлангийн талаар М.Фуко уг бүтээлдээ эшлэсэн байсныг мөн дам эшлэв. Бэйлийн тайлангийн хэсгийг эндээс үзэж болно. A.L.J.Bayle, Nouvelle doctrine des maladies mentales (Paris, 1825, pp. 23–4).

⁴ Тус бүтээлд М.Фуко Москатигийн бүтээлээс эшлэсэн байсныг энд дам эшлэн оруулав. Дурьдан буй агуулгыг эндээс дэлгэрэнгүй үзэж болох юм. P. Moscati, De l'emploi des systèmes dans la médecine pratique (Fr.trans., Strasbourg, Year VII, p. 13).

⁵ 1658 онд Франсуа де ла Бое Лейден дэх эмнэлэгт клиник сургууль, XVI зууны сүүлчээс Падуа хотод эмнэлзүйн анагаах ухааны тэнхим байж магадгүй газар, 1720 онд Бюерхаавын зарим дагач Эдинбургийн их сургуульд шинэчлэл хийж, Лейдений загвараар сургалтын эмнэлэг байгуулж, тэдний жишээг Лондон, Оксфорд, Кембриж, Дублин зэрэгт дагажээ. 1770 онд Лакассайн, Бурру, Гилберт, Коломбиер нар цочмог тохиолдлуудад зориулсан жижиг, арван хоёр ортой эмнэлгийг хувийн болон өөрсдийн зардлаар зохион байгуулахыг оролдсон ч энэ төсөл амжилтгүй болов. Мөн цэргийн эмнэлгүүдэд эмнэлзүйн сургалтыг анх зохион байгуулж байсан Кабанис жишээ болгон Дубрейлийн Маречал де Кастрисийн ивээл дор байгуулсан Брест дэх тэнгисийн цэргийн эмнэлгийн дэргэдэх клиникийг цэргийг эш татахын зэрэгцээ эцэст нь 1787

Хэдийгээр эдгээр клиник нь сургалтын болоод зохион байгуулалтын шинэ арга хэлбэр мэт боловч тэдгээрийн ач холбогдлыг бууруулах хэд хэдэн ажиглалтыг дахин нягтлах хэрэгтэй хэмээн тэрээр дүгнэв. Учир нь түүнийхээр прото клиникүүдийн бүтэц хожим нь XIX зуунд шинээр бий болсон эмнэлгүүдтэй харьцуулахад дараах хэдэн зүйлээр ялгаатай байлаа. Үүнд:

- Эмнэлгийн үүрэг бол тохиолдол бүрийг эмчлэх биш, харин өвчнийг цогцоор нь эмчлэхэд анхаарах явдал байсан. Иймд өвчний ангиллыг судлахад анхаарах ёстой байв.
- Клиник, эмнэлэг хоёрын өвчтөнийг авч үзэж буй байдал нь өөр өөр. Эмнэлгийн орчинд эмч өвчтөний биед нуугдсан өвчнийг илрүүлэхийг зорьж, өвчтөн нь өвчний субъект болж байдаг бол клиникт өвчтөн зөвхөн өвчнийг судлах, ойлгох хэрэгсэл төдий болдог. Тодруулбал эмнэлэгт “өвчтөн нь судлах учиртай тохиолдлын субъект”, харин клиникт бол “өвчтөн нь өвчний санамсаргүй тохиол, тухайн өвчин түр зуур орогносон объект” болдог.
- Клиникийн нөхцөлд өвчин бол шинжилгээ/тестийн агуулгатай асуулт ер биш, харин илрүүлэн нээх (decipher) агуулгатай ажил болж хувирсан байв. Тухайлбал энэ үед клиникийн өвчтөн бүрт хоёр оюутан заавал оногддог байсан бөгөөд, оюутны харц нь анагаахын харц биш, харин нэгэнт мэдэгдсэн тэрхүү үнэнийг илрүүлэх харц байжээ.
- XVIII зууны клиникүүд зөвхөн сургалтын зориулалттай байсан тул тэр үеийн клиникүүдэд ганц л чиглэл байв. Тус чиглэл нь “дээрээс доош” буюу “мэдлэгээс үл мэдэхүй рүү” чиглэсэн чиглэл байсан юм.
- Клиникт өрнөж буй багш/чиглүүлэгчийн яриа (speech) нь хэдий дидактикийн чанартай байж болох ч эцсийн дүндээ ирээдүйд учрах эрсдэл бүхнийг агуулсан тоглоомын хэлний төдий байв. Үүнийг Пьер-Жозеф Дезо (1738-1795)⁶ гийн жишээгээр (Foucault. M, 1973, p.58-61) харуулдаг.

Дүгнэн үзвэл М.Фукогийн “Клиникийн үүсэл” бүтээл нь түүний структурализмд шилжиж эхэлсэн үед хамаарна. Тэрээр уг бүтээлдээ XVIII-XIX зууны эхэн үеийн Францын клиникийн үүслийг авч үзсэн билээ. Түүнийхээр хүн төрөлхтний эхэн үеийн анагаахын мэдлэг багшийн заасныг шавь ямар нэгэн шүүлтүүргүй хүлээн авч, шууд дагадаг байдал XIX зууны эхэн үеэс өөрчлөгджээ. Ингэж өөрчлөгдөх болсон шалтгаан нь уг ба юмсын хооронд шинэ холбоо бий болж, улам тэлсээр, хүний харах болон хэлэх боломж нэмэгдсэн нь туршлагын мэдлэг, түүний бүтцийн өөрчлөлт болон онолын хэлний тэмдэглэгээг нэмэгдүүлжээ. Мөн анагаах ухаан мэдлэгийг системтэй олгох зорилгоор шинэ сургалтын систем бий болсон нь прото клиникүүд байлаа. Гэвч эдгээр прото клиник зохион байгуулалтын хувьд зарим нэг дутагдалтай байсныг М.Фуко онцлоод, XVIII зуунд прото клиник нь зөвхөн тохиолдлын талаархи мэдлэгийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлдэг анагаахын практикийг заах хэрэгсэл хэмээн үзсэн ажээ.

Ном зүй

Бум-Очир, Д., Мөнх-Эрдэнэ, Г. (2018). *Нийгэм-соёлын хүн судлалын онолын үүд*. Улаанбаатар, Монгол: МУИС Пресс .

Гомбосүрэн, Ц. (2010). *Хэлний философи ба хэл шинжлэлийн (лингвистик) философи*. Улаанбаатар, Монгол: МУИС-ийн хэвлэх үйлдвэр.

онд Копенгаген хотод амаржих газар байгуулагдсан (Foucault. M, 1973, p.57-58) зэргийг М.Фуко баримтаар онцолдог.

⁶ 1784 онд П.Дезо нь Hôtel-Dieu (Франц дахь хамгийн эртний бөгөөд тасралтгүй үйл ажиллагаа явуулж буй эмнэлэг)-д мэс заслын боловсрол олгодог мэс заслын клиник сургууль нээсэн. Түүний сургуульд Францын өнцөг булан бүрээс олон суралцагч ирдэг байсан бөгөөд түүний лекц байнга 100 (тухайн цаг үедээ байж болох хамгийн олон гэдэг утгаар) орчим сонсогчтой байсан. П.Дезо нь мэс заслын практикт их олон багаж хэрэгслийг бий болгосон. М.Фуко түүний клиник сургуулийн талаар дараах бүтээлээс эшлэсэн байсныг энд дам эшлэн оруулав. Дурьдан буй агуулгыг дараах бүтээлээс дэлгэрэнгүй үзэж болох юм.

М.-А.Petit, ‘Éloge de Desault’, Médecine du Coeur, p. 108.

Гомбосүрэн, Ц. (2021, 11 сарын 18). *Мишель Фукогийн боловсруулсан дискурсив (уялдмал эргэцүүллийн) арга зүйн зарим гол бүрэлдэхүүн*. Олон нийтийн дискурс дэх философийн үүрэг эрдэм шинжилгээний бага хурал, Улаанбаатар, Монгол.

Отгонбаяр, М., Онон, Ц., Энхбаяр, Б., Баасандорж, Э., Мөнхжавхлан, Б., Дагзмаа, Б., Бүжинлхам, С., Гомбосүрэн, Ц., Нямсүрэн, Ц. (2023). *Нийгэм-Улс төрийн философийн орчин үеийн онолууд*. Улаанбаатар, Монгол: Тотопресс.

Dreyfus, H. L. (1983). *Michel Foucault, beyond structuralism and hermeneutics*. United States of America: The University of Chicago Press.

Gutting, Gary and Johanna Oksala, "Michel Foucault", *The Stanford Encyclopedia of Philosophy* (Fall 2022 Edition), Edward N. Zalta & Uri Nodelman (eds.), Retrieved from <https://plato.stanford.edu/entries/foucault/>.

Hurst, A. (2017, July 26). *Post-Structuralism*. Oxford Bibliographies in Literary and Critical Theory. (E. O'Brien, Editor) doi:10.1093/obo/9780190221911-0008.

Foucault, M. (1973). *The Birth of the Clinic: An Archaeology of Medical Perception*. Vintage Books.

The Medical Discourse and Its Structural Transformation: M. Foucault's View on the Evolution of Medical Perception

*Michel Foucault (1926–1984), a cultural theorist and historian, was a key figure in the philosophy of history. This article examines the medical discourse and structural transformations discussed in his seminal work *The Birth of the Clinic: An Archaeology of Medical Perception* (1963). Foucault analyzes the evolution of French medicine from the 18th to the early 19th century, focusing on medical discourse. He attributes the rapid advancement of medical knowledge during this period to physicians' treatment records, written less than a century apart. Foucault argues that early medical knowledge was traditionally transmitted vertically, from teacher to student. However, he identifies a shift in the early 19th century, driven by the growing influence of experiential knowledge and structural changes in medical practices. Foucault also explores the rise of proto-clinics, institutions designed to systematically disseminate medical knowledge, and offers a unique explanation of the changing roles of the patient and disease in clinical and proto-clinical settings.*